

ДОКТОР Г.СҮХБААТАР БОЛ ДЭЛХИЙН ХЭМЖЭЭНИЙ ЭРДЭМТЭН МӨН

*Л.Хайсандай**

Нэгэн ухаантан өгүүлсэн нь: “Өчигдрийг мартаж болохгүй, яагаад гэвэл тэр нь маргаашийн багш, өнөөдөр шиг хол юм үгүй, яагаад гэвэл тэрээр эргэж ирэхгүйгээр одно, маргааш шиг ойрхон юм байхгүй, учир нь гэвэл тэр ирж явна” гэсэн байдаг.

Үүн лүгээ адил өнгөрсөн, одоо, ирээдүй гэсэн гурван их цагийн эргэлт, тэдгээрийн хоорондын нягт уялдаа холбоонд нь ямарваа улс орны түүхэн замнал, алив хүний амьдралын зам мөр, ажил үйлсийн үнэ цэнийг авч үзвээс жинхэнэ шинжлэх ухааны онол, арга зүй, ёс суртахууны хувьд хамгийн зөв, үнэн бодитой, цэгцтэй судалгаа, гаргалгаа болдог байна. Энэ үүднээс, энэ үзэл хандлагаар болгоовол доктор Г.Сүхбаатарын амьдралын мөр цагаан, эрдмийн үйл нь арвин бөлгөө. Энэ бол нэгэн бахархал!

Г.Сүхбаатар амьдралынхаа 40 шахам жилийг Монголын эртний түүхийн судалгааны ажилд зориулж “Сүмбэ”, “Монголчуудын эртний өвөг”, “Монгол Нирун улс” зэрэг нэгэн сэдэвт зохиолууд туурвиж, хүннү, сүмбэ нар нь эртний монгол угсаатан мөн, нирун нь язгуур монголчууд мөн болохыг шинжлэх ухааны үүднээс, олон талаас нь нотлон харуулж, язгуур монголчуудын түүхийг цоо шинэ санаа дүгнэлтүүдээр баяжуулан, түүний үечлэлийг олон зуун жилээр урагшлуулсан нээлт хийсэн юм.

Монголын түүхийн шинжлэх ухаанд оруулсан Г.Сүхбаатарын нээлтүүдийг дотоод, гадаадын түүхчид, томоохон эрдэмтэд өндрөөр үнэлдэг байв.

Г.Сүхбаатар доктор нь шинжлэх ухааны шударга зарчмыг хатуу баримталж, олон орны судлаачид ялангуяа түүхчид, онолчдын эрдэм шинжилгээний бүтээл туурвилтай байнга танилцдаг, өөрийн судалгааг дэлхийн төвшинд, тэднээс дутахааргүй, харин ч илүү гаргахаар ямагт хичээнгүйлэн ажилладагаараа үнэхээр гаргуун нэгэн байв. Тэрээр өрөөл бусдын санааг хуулах биш, өөрийн санаа боллыг өрөөл бусдад хүртээгч, хандивлагч эрдэмтэн байсан юм. Монгол төр улс, монголчуудын эртний түүхийн асуудлыг судлана гэдэг бол үнэхээрийн их эр зориг, эрдэм мэдлэг, арга ухаан, хичээл зүтгэл, тэсвэр хатуужил шаардсан маш нарийн чимхлүүр ажил гэдгийг бид бүхэн сайн мэднэ. Энэхүү нууц эрдмийн “ертөнц” рүү нэвтрэн орж, эрдэнэсийн үнэ цэнэтэй шүр сувд шүүрэн олж илрүүлэн судлаж нээсэн их гавъяатай хүн бол яахын аргагүй

* Л.Хайсандай - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор (Sc.D), профессор

Г.Сүхбаатар доктор мөнөөс мөн бөлгөө. Энд нэг зүйлийг тодруулж залруулахад тэрээр зөвхөн нэн эртний түүхийн мэрэгжилтэн төдийгүй Монголын дундат ба шинэ, шинэхэн үеийн түүхийн нэртэй төлөөлөгч байсан юм. Нөгөөтэйгүүр, тэрээр дэлхийн хэмжээнд нүд тайлж, дэлхийн хэмжээний хүмүүстэй нүүр учирч, дэлхийн хэмжээнд сэтгэж, бодож, бүтээж, туурвиж явсан энэ аугаа их хүний нэр алдар, зохиол бүтээл нь Монголдоо төдийгүй дэлхийн олон оронд дурсагдан яригдаж мөнхжсөн байна. Хэн дуртай аавын хүү алдрын ийм өндөрлөгт тэр болгон хүрч үл чадмой. Энэ тухай ганц, хоёрхон жишээн дээр хэлэхийг оролдоод үзсү. Монголын ба дэлхийн орнуудын, ялангуяа дорнодахины улс түмний түүх, хэл соёлын талаар тэр ямар их өргөн хүрээний мэдлэг боловсролтой, бичлэгийн ямар их чадвартай, ой сэтгэмжтэй, судлагааны ямар их арга туршлагатай эрдэмтэн болохыг нэгд: Зөвхөн “Монголчуудын эртний өвөг” хэмээх нэгэн сэдэвт зохиолоо бичсэнээс нь яруу тод харж болно. Уг зохиолыг тэрээр бичихдээ дотоод, гадаадын түүхч-эрдэмтдийн нийт 504 нэр төрлийн ном зохиол, сурвалж судар, түүний дотор монгол хэлээр 103, орос хэлээр 210, англиар 104, хятадаар 81, японоор 6 нэрийн ном бүтээл, сурвалж бичиг үзэж танилцаж, судлаж нягталж авч ашигласан байдаг юм. Энэ бол үнэхээр гайхамшиг!

Хоёрт: Тэрээр гадаадын олон хэл, тухайлан орос, хятад, англи, япон хэлийг сайн мэддэгийнхээ хувьд олон орны эрдэмтдийн хэдэн арван зохиол бүтээлтэй биечлэн нэг бүрчлэн танилцаж, уншиж судлаж, үр дүнтэй ашигладаг, тэд ч доктор Сүхээгийн бүтээлүүдийг ширээнийхээ ном болгож үргэлж харж үзэж ашигладаг хийгээд тэд нар хоорондоо боломж бололцоо л гарвал уулзаж учирдаг, санал бодлоо харилцан ярилцаж хэлэлцдэг, бичиг захидал, ном хэвлэлээ тогтмол солилцдог, ерөнхийдөө байнгын харилцаа холбоотой байдаг байсан аж. Заримаас нь дурьдвал:

ОХУ-ын нэртэй түүхч-эрдэмтэн Лев Гумилев, Сергей Тихвинский, Владимир Месняков, Сергей Кляшторный, Юрий Рычков, монголч эрдэмтэн Марк Гольман, Г.Слерчук, С.Рошин, АНУ-ын О.Латтимор, Р.Рупин, Ф.Фукуяма, Английн Ч.Бауден, Онон Өргөнгөө, Австралийн И.Рачевили, Францын Ф.Нормандии, Болгарын С.Дончев, Арменийн А.Закиян, Японы Хашимото, Морита Юузо, Хятадын Хуан цзитао, Яина, Түвшин, Германы В.Хайссиг, В.Вайт нарын зэрэг олон эрдэмтнийг ихэд хүндэтгэн харилцдаг байж. Харин олон сайхан өөр бусад эрдэмтний нэр орхигдсон байж магад. Хүлцэл өчсү. Монголынхоо эрдэмтэн андуудыг нь энд дурьдсангүй. Бид бүгд сайн мэдэх юм чинь.

Гуравт: Доктор Сүхбаатар бол зөвхөн Монголын эртний түүх, эртний дорнодахины түүх судлаач хүн төдий биш. Тэрээр орчин үетэйгээ хөл нийлүүлэн явдаг, цаг үеэ сайтар мэдэрч ойлгодог, ирээдүйгээ зөв совингоор төсөөлж илэрхийлдэг өнөө цагийн нэртэй эрдэмтэн хүн.

Энэ чанараараа Монголын дорнодахин, олон улс, гадаад харилцаа судлалаар бүтээл туурвидаг, үнэн шударга үгээ хэлж үнэлэлт дүгнэлт гаргадаг сайн шинжээч, сайн зөвлөгч, сайн багш байв.

Өөрөөр хэлвэл эрдэм номын ирмүүн амьдрал, их ажил үйлсийнхээ сүүлийн 10-аад жилийг манай хүрээлэнд, бидний дунд, бидэнтэй хамт хамгийн их эрч хүч, урам зориг, баяр бахдалтайгаар өнгөрөөсөн ахул бидний “хамтлагийн” эрдэмтэн, манай харъяалалын хүн байсан юм. Энэ тухай бид чингэж хэлэх эрхтэй, бахархаж ярих учиртай. Амьд сэрүүн явахад нь нэг их сүйд болж дотносдоггүй, холхон хөндийхөн байдаг зарим хүн өнөөдөр “нугасгүй” хайртай дуртай, өнгө зүс, үг яриа нь их л өөр болчихсон байгааг хараад “гайхахын” хамт бас баярлаж байна. Юм гэдэг нэг янзаар байдаггүйн гэрч энэ буюу.

Доктор Г.Сүхбаатар манай хүрээлэнд ажиллах хугацаандаа “Монгол-Нирун улс” хэмээх бүтээлээ бичиж дуусган, эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлж хэвлэлд шилжүүлээд нийтийн хүртээл болгож байв. Бас хүрээлэнгийн судлагааны чиглэлд шууд хамаарах эрдэм шинжилгээний хэд хэдэн дорвитой өгүүлэл бичиж нийтлүүлсэн юм. Тэдгээр нь нэгд: 1993 онд бичиж, “Зүүн хойт Ази судлал” сэтгүүлийн №1-д хэвлүүлсэн “Монгол Улсын үндэсний эрх ашиг” хэмээх өгүүлэл, Хоёрт: 1995 оны эхээр бичиж мөнхүү сэтгүүлийн 1996 оны №1-2-т (бурхан болсны дараа) нийтлэгдсэн “Монгол Улсын түүхэн хөгжлийн Вектор” гэсэн өгүүлэл юм.

Энэ хоёр өгүүлэл нь хамарсан хүрээний асуудал, дэвшүүлсэн шинэ санаа сэдэл, тэдгээрийн шинэлэг байдал, үнэ цэнийн хувьд томоохон монографи зохиолтой эн зэрэгцэхүй ч хэмжээний эрдмийн бүтээлүүд мөн. Эхний өгүүлэлд Монгол Улсын үндэсний эрх ашгийг дөрвөн үндсэн бөлөг хэсгээр тодорхойлж гаргаад, түүн дотроос Монгол Улсын төрийн тусгаар тогтнолыг эрхэмлэн хамгаалж бататгах, Монгол үндэстний экологи, Монгол соёлын экологи, газар нутаг, хил хязгаар, байгалийн унаган төрхийг хадгалж хамгаалах асуудлыг онцгойлон авч үзсэн байгаа. Энд түүх, соёлын асуудлыг эн тэргүүнд тавьж, түүх соёлоо судлаж мэдэхгүйгээр өнөөг байгуулж, ирээдүйг цогцлоож чадахгүй гэсэн санааг илэрхийлээд “Монгол үндэстний түүх бол гагцхүү монголчуудын түүх бөгөөд харин хол ойрын өөр харь үндэстний юм уу, бусад ямарваа улс орны түүх биш ээ!

Монголын соёл нь зөвхөн монгол үндэстнийх, өрөөл бусдаас зээлдэж авсан юмуу, хуулж дуурайсан соёл огтхон ч бишээ. Зөвхөн Монгол хөрсөнд “ургаж”, монголчуудад заяаж бий болсон, уламжилж хөгжиж ирсэн бидний соёл, манай соёл...” хэмээн бат нот тодорхойлж, батлаж нотлосон байдаг. Бас түүхийг мэдэхгүйгээс гадна түүхийг гуйвуулахын эсрэг хатуу зогсдог, тууштай тэмцдэг нэгэн байв. Үүнийгээ Дагестаны нэрт яруу найрагч Расул Гамзатовын айлдсан уран үгээр

бодол санаагаа илэрхийлэн хэлэх дуртайсан. Тэр нь “Өнгөрсөн үеэ та нар гар буугаар буудвал ирээдүй та нарыг их буугаар буудах болно шүү” гэсэн үг болой. Ерөөс эх түүхээ, эх соёлоо судалж мэдэж, баяжуулж хөгжүүлж байх аваас эх орноо дээдлэх, эрх чөлөө, тусгаар тогтнолоо хамгаалан бататгах үзэл сэтгэлгээ бэхжиж, улс орон урагшилж хөгжиж чадна гэдэг итгэл үнэмшил доктор Г.Сүхбаатар агсанд нэвт шингэсэн байсан юм. Үүгээрээр тэрээр маш тууштай эх оронч, улс үндэстнээ бишрэн дээдлэх үзэлтэй, түүнийхээ төлөө эр зоригтой, үнэн үгээ хэлж эрс шийдэмгий тэмцдэг нэгэн байв. Доктор Г.Сүхбаатар гуай “Үнэн” сонины сурвалжлагчид өгсөн нэгэн ярилцлагадаа: “Миний эрхэмлэдэг оройн дээд шүтээн минь Монголын тусгаар тогтнол юм шүү. Үүнээс өөр эрхэм юм юу байх билээ” гэсэн (“Үнэн”, 1992-03-25N33) байдаг.

Нөгөө хоёр дахь өгүүллийн гол санаа нь мөн л дээр өгүүлсэн зүйлийн шууд үргэлжлэл гэж болох бөгөөд эх оронч сэтгэлтэй, эрдэм боловсролтой хүмүүс л улс орноо урагш нь хөгжүүлж, улсын дайтай улс, айлын дайтай айл байлган авч явж чадна гэсэн санаа юм. Сайн сайхан амьдрая, эрх чөлөөтэй тусгаар улсын бүрэн эрхт иргэн байяа л гэвэл үндэснийхээ түүх соёлоос суралцаж, эрдэм боловсрол эзэмш, ажиллаж хөдөлмөрлө, хичээж зүтгэ хэмээн сургамжилсан байгаа юм. Энэ бүх боломж, бололцоо, зам мөрийг нээж өгсөн манай ахмад үеийнхэн, ХХ зууны эрэлхэг зоригтой эх орончид, ухаант тэр хүмүүсийн алдар гавьяа мөн юм шүү гэдгийг сануулан хэлж, тэр бүхнийг “бүү март, мартвал сөнөнө шүү” хэмээн өгүүлсэнд уг өгүүллийн үнэ цэнэ, ач холбогдол оршино гэж тодотгон онцолж хэлмээр байна. Халуун эх оронч эрдэмтэн Г.Сүхбаатар насан туршдаа Монгол орон, Монголын ард түмний эрх чөлөө, тусгаар тогтнолын түүхэн замнал, үндэсний түүх соёлоо дээдлэн хүндэтгэж, бататган бадруулахын төлөө, тэр бүгдийг дотоод, гадаадад ямар нэгэн хэлбэрээр ор үндэсгүй буруутган үгүйсгэх, мушгин гуйвуулахын эсрэг эрс шийдэмгий тэмцэж ирсэн юм. Энэ нь дараах хоёр эрдэм шинжилгээний үндэслэлтэй шүүмж-няцаалтаас тодорхой харагдана. Үүнд: Нэгдүгээрт: 1991 онд Хөх хотод хэвлэгдсэн “Өвөр Монголын нэвтэрхий толь” хэмээх 1000 гаруй хуудастай эл номонд Монголчууд, Монголын төр улсын гарвал үүслийг мушгин гуйвуулж, “Хүннү, Сүмбэ, Нирун нар нь түүхийн хувьд Хятадын харьяа уугуул овог аймгийнхан хийгээд бүрэлдүүнд нь ямагт багтаж ирсэн цөөнх үндэстэн, нүүдэлчдийн улс мөн” гэж бичжээ. Энэнд доктор Г.Сүхбаатар түүхийн шинжлэх ухааны баттай бодитой баримт сурвалжуудад тулгуурлан эрдэм шинжилгээний үндэслэлтэй шүүмж бичиж няцаалт өгсөн. Тухайлвал түүхийн үүднээс үзэхүл Монгол Хятадын нэг хэсэг хэзээ ч байгаагүй. Хоёул өөр хоорондоо тодорхой хил хязгаартай, хэл соёл, зан заншил, шүтлэг, амьжиргааны хэв маягаар

эрс тэс ялгаатай байсан хийгээд аль алин нь тус тусдаа бие даасан тусгаар улсууд байсан гэсэн итгэл үнэмшилтэй хариулт өгч, дээрх гуйвуулгыг няцаасан байдаг.

Хоёрдугаарт: 1994 оны 4-р сард Хятадын Ардын хэвлэлийн газраас эрхлэн Бээжинд “Гадаад Монголын тусгаар тогтнолын нууц үгсэл (Вай Мэнгу дули нэйму)” хэмээх хятад ханз үсгийн 480 тал хуудастай, газрын зураг хоёртой, 11 гэрэл зурагтай номыг 50000 хувь хэвлэн гаргасан байдаг. Энэ том номыг хятад хэлнээс монгол хэл рүү орчуулах нүсэр хүнд ажлыг эр биеийн тэвчээр, эрдэм мэдлэгийн хүчээр бусад хэдэн хүнтэй хамтран гүйцэтгэж, төр, засгийнхаа сонорт илтгэн айлтгаж, хариу няцаалт өгөх үүрэг даалгавар авчээ. Энэ ном бол гэнэтийн санамсаргүй гарсан биш бөгөөд олон жилийн далд, нарийн бодлогын нэг илрэл мөн гэдгийг доктор Г.Сүхбаатар нотлоод энэ нь БНМАУ (Монгол Улс)-ын тусгаар тогтнолыг үгүйсгэн устгаж, БНХАУ-д нэгтгэн нийлүүлэх алсын зорилготой БНХАУ-ын төрийн стратегийн хагас далд бодлогыг хэрэгжүүлж дуусгахад хятадын ажил хэрэгч хүмүүс, тухайлан үйлдвэр, худалдаа-арилжааны хүмүүсийг одоогийн зах зээлийн нээлттэй эдийн засгийн шинэ нөхцөл байдалд зохицуулан ашиглаж дэвэргэн өдөөж, хүчлэн дайчлахад чиглэгдсэн ном мөн болохыг батлаад түүний гол агуулга зорилго, хандлага, бичлэгийн өнгө аясд шүүмжлэлтэй хандан, тэр бүхний цаадах учир начир, жинхэнэ мөн чанар, хуурамч нүүр царайг түүхийн хөдөлшгүй баримт сэлтээр нотлон харуулж, тодорхой няцаалт өгч чадсан цорын ганц эрдэмтэн мөн бөлгөө. Уг номын 7 томоохон бүлэг, олон арван зүйл бүрийг нь шинжин судалж, тус бүр дээр нь няцаасан үнэлэлт дүгнэлт гаргасан байгаа юм. Энэ бол хэн дуртай нэг нь хийчихдэг зүйл огтхон ч биш бөгөөд асар их хөдөлмөр зүтгэл, итгэл, сэтгэл, эрдэм мэдлэгийн цар хүрээ, чадвар чансаа шаардсан ажил байсан. Энэ бүгдийг тэрээр туйлын зориг тэвчээр, ухаан санаа гарган амжилттай даван гарч чадсан юм.

Бас эдгээрийн зэрэгцээгээр нобелийн шагналтны шилдэг “16 дүгнэлт”-ийн хэсгийг англи хэлнээс шууд орчуулж, эрдэмтэн судлаач, багш, оюутан болон өргөн олон нийтэд зориулан нийтлэж, эрдэм мэдлэгийн нь санд “эрдэнийн” хандив өргөж байлаа. Монголоо гэсэн халуун сэтгэл, дэлхийг гэсэн сайн санаа, эрдмийг дээдэлсэн бишрэл, түүний биелэл болох ном бүтээл, үнэнийг баримталсан шударга зан үйл энэ бүхэн Г.Сүхбаатар доктор агсныг дэлхийн хэмжээний эрдэмтэн болгож өргөмжилсөн бөлгөө.

Номын нь дор мөргөмү, ариун цагаан буянт үйлийн нь дор сүсэглэмү.